



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 16 өдөр

Дугаар А/517

Алтай хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, 46.1.3 дахь заалт Үнэлгээний хорооны 2022 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 95 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх ГААОНӨГ/202205081 дугаартай Есөнбулаг сумын 1 дүгээр сургуулийн охидын дотуур байрны ариун цэврийн байгууламжийн засварын ажлыг “Хайчийн нуруу” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т олгосугай.

2. Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтанзагас)-т үүрэг болгосугай.

3. Ажлын санхүүжилт, гүйцэтгэл, чанарт хяналт тавьж ажиллахыг Санхүү төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Хурцгэрэл)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ